



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 176

Мандалговь

Г

Шагнах тухай

Т

Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.10, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тогтоолоор батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.3, аймгийн Засаг даргын 2013 оны А/565 дугаар захирамжаар батлагдсан “Шагналын жишиг тогтоох тухай журам”-ын 2 дугаар бүлгийн 2.2 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2017 оны 4 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

Нэг. Дэлгэрхангай сумын угуул, Үндэсний Урлагийн их театрын гоцпол дуучин, уртын дуучин Сосорбурам овогтой Цогтсайхан нь мэргэжлийн урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй хөдөлмөрлөн, Монгол ардын урлагийг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмрээ оруулж, Төрийн дээд шагнал “Монгол Улсын Гавьяат жүжигчин” цол хүртсэн тул аймгийн Засаг даргын “Хүндэт өргөмжлөл”, мөнгөн шагналаар шагнасугай.

Хоёр. Мөнгөн шагналд 500000 /Таван зуун мянга/, хүндэт өргөмжлөл хэвлүүлэхэд 35000 /Гучин таван мянга/, нийт 535000 /Таван зуун гучин таван мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга /О.Чулуунбат/, нягтлан бодогч /Ц.Даваа/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

022220100